



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/25

Бат-Өлзий сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх
арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.11 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 7 дугаар зүйлийн 7.3.2, 7.3.3, 7.3.6 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6 дахь хэсэг, "Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай" аймгийн Засаг даргын 2023 оны А/117 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг 2023 оны 05 дугаар сарын 05-аас 2023 оны 10 дугаар сарын 20 хүртэл хугацаанд үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг "Хустын-Рашаан" мал эмнэлгийн эзэн (Б.Батбилэгт), "Хутагт уулын өгөөж" мал эмнэлгийн захирал (П.Содномбалжир) нарт үүрэг болгосугай.
2. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын хуваарийг 1 дүгээр хавсралтаар, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2023 оны туулгалт, боловсруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт, халдваргүйтгэлийн төлөвлөгөөг 3 дугаар хавсралтаар, лабораторын төлөвлөгөөг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.
3. Урьдчилан сэргийлэх ажлын явц, чанар үр дүнг тооцон санхүүжилтийг олгон, баримт бичгийн бүрдүүлэлт мэдээ тайланд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Мал эмнэлгийн улсын байцаагч (П.Аюушжав)-д үүрэг болгосугай.
4. Бат-Өлзий сумын хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж, устгах, орчны цэвэрлэгээ ариутгалын ажлыг 2023 оны 05 дугаар сарын 05-аас 2023 оны 05 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулахыг багийн Засаг дарга нар, мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (Хустын рашаан, Хутагт уулын өгөөж)-д тус тус үүрэг болгосугай.
5. Хорогдсон мал амьтны сэг зэм цстгалын тайланг нэгтгэн 2023 оны 05 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг багийн Засаг дарга (Г.Бямбагарав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

622301244

Сумын Засаг даргын 2023 оны...⁰⁵
дугаар сарын ⁰⁹ны өдрийн ^{А/25}
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ВАКЦИНЖУУЛАЛТЫН ХУВААРЬ

№	МЭҮНэгжийн нэр	Малын төрөл	Боом	Галзуу	ДХХ	Цусан халдварт	ДХХ-энтер
1	"Хустын-Рашаан" МЭҮН	Бод	3.0	1.0		5.0	
		Бог			11.8		7.8
2	"Хутагт Уулын өгөөж" ХХК	Бод	2.0			4.0	
		Бог			9.2		2.2
Нийт			5.0	1.0	21.0	9.0	10.0

-оОо-

Сумын Засаг даргын 2023 оны...⁰⁵
дугаар сарын...⁰⁹ны өдрийн ^{11/25}
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



ШИМЭГЧ ӨВЧНӨӨС ЭМЧЛЭН СЭРГИЙЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн нэр	Малын төрөл	Угаалганд хамрагдах малын тоо	Туулгалтанд хамрагдах малын тоо	Боловсруулалтанд хамрагдах малын тоо	Нийт хамрагдах малын тоо
1.	"Хустын – Рашаан" МЭҮН	Бод		56630	56620	113250
		Бог	46280	103390	103380	253050
		Нохой		50		50
		Дүн	46280	160070	160000	366350
2.	"Хутагт-Уулын өгөөж" ХХК	Бод		36160	36165	72325
		Бог	81890	81890	81850	245630
		Нохой		50		50
		Дүн	81890	118100	118015	318005
Дүн:			128170	278170	278015	684355

Сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 04 ны өдрийн 11/2 дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээний нэр		"Хустын-Рашаан" МЭҮН	"Хутагт-Уулын өгөөж" ХХК	Нийт тоо хэмжээ
	Зоорь агуулах	Тоо ширхэг		2	2
		Талбай, мкв		200	200
	Малын хашаа	Тоо ширхэг	60	60	120
		Талбай, мкв	42000	42000	84000
	Худаг уст цэг	Тоо ширхэг	7	7	14
		Талбай, мкв	240	240	480
	Тэжээлийн агуулах	Тоо ширхэг	1	2	3
		Талбай, мкв	150	150	300
	Нийтийн эзэмшлийн талбай	Тоо ширхэг			
		Талбай, мкв			
	Тээврийн хэрэгсэл	Тоо ширхэг	10	10	20
		Талбай, мкв	160	160	320
	Мал амьтны тоног хэрэгсэл	Тоо ширхэг			
		Талбай, мкв			
	Түүхий эд бүтээгдэхүүн хадгалах цэг	Тоо ширхэг	3	3	6
		Талбай, мкв	300	300	600
	Голомтын бүсийн талбай	Тоо ширхэг	2	5	7
		Талбай, мкв	5000	2000	7000
	Устгалын цэгийн талбай	Тоо ширхэг			
		Талбай, мкв	2000	2000	4000
	Өтөг бууц	Тоо ширхэг			
		Талбай, мкв			
	Бэлчээрийн талбай	Тоо ширхэг			
		Талбай, мкв			
	Нийт талбай, метр.кв		49850	47050	96900

Сумын Засаг даргын 2023 оны...⁰⁵
дугаар сарын...⁰⁹ны өдрийн...^{17/20}
дугаар захирамжийн дөрөвдүгээр хавсралт

ЛАБОРАТОРИЙНТАНДАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн нэр	Малын төрөл	Бруцеллёз	Баас	Сүү	Арьсны сорил	
						ям	сүрьеэ
1.	"Хустын – Рашаан" МЭҮН	Хуц	170	20	40		
		Ухна	120				
		Бух	75				
		Дүн	365				
2.	"Хутагт-Уулын өгөөж" ХХК	Хуц	140	25			
		Ухна	130				
		Бух	60				
		Дүн	330				
Дүн:			695	45	40	-	-